



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

### “Мазаалай олон улсын цас мөсний наадам” арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/90 дүгээр захирамж, нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар баталсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд туссан үндэсний онцлогтой дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилт, “Монголд зочлох жил”-ийн зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангах, цас мөсний дээд амжилтыг тогтоох зорилгоор Байгаль орчин, Аялал жуулчлалын яамтай хамтран “Мазаалай олон улсын цас мөсний наадам” арга хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 14-28-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Наадмыг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталж, шаардагдах 94,780,740 (ерэн дөрвөн сая долоон зуун наян мянга долоон зуун дөч) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.

3.Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2024 оны 01 сарын 06 өдрийн  
..... дугаар тушаалын хавсралт



**“МАЗААЛАЙ ОЛОН УЛСЫН ЦАС МӨСНИЙ НААДАМ” АРГА ХЭМЖЭЭГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
<b>Аюулгүй ажиллагааны хяналтын зардал (НОБГ)</b>				
1	Шатхууны зардал	366 л	3890	1,423,740
2	Албан хаагчдын хоолны зардал	3 хүн x 15 өдөр	18,000	1,620,000
<b>Дүн</b>				<b>3,043,740</b>
<b>Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ (НЭМГ)</b>				
3	Эмнэлгийн тусламж үйлчилгээний зардал	15 өдөр	400,000	6,000,000
<b>Дүн</b>				<b>6,000,000</b>
<b>Нийтийн аюулгүй байдал (НЦУГ)</b>				
4	Хамгаалалтад ажиллах алба хаагчдын хоолны зардал	15 өдөр x 20 хүн	18,000	5,400,000
5	Хамгаалалтын хайс тээвэрлэх автомашины зардал	150 л	3890	583,500
6	Хамгаалалтын үеийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг тээвэрлэх, хяналт шалгалтаар ажиллах автомашины шатхууны зардал	1200 л	2390	2,868,000
<b>Дүн</b>				<b>8,851,500</b>
<b>Замын хяналт, аюулгүй байдлын зардал (ЦЕГТЦАЗЦГ)</b>				
7	Алба хаагчдын хоолны зардал	15 өдөр x 13 хүн	18,000	3,510,000
8	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт, зохицуулалтад хяналт шалгалтааражиллах авто машины зардал	3 ш	450 л	1,075,500
<b>Дүн</b>				<b>4,585,500</b>
<b>Нээлтийн урлаг соёлын арга хэмжээ (НСУГ)</b>				

9	Нээлтийн арга хэмжээний уран бүтээлчдийн шатхууны зардал		300,000	300,000
10	Нээлтийн бүжгийн чуулга	Багц	1,000,000	1,000,000
Урлаг соёлын арга хэмжээ (БОАЖЯ)				
11	Урлагийн арга хэмжээ	Багц	50,000,000	50,000,000
<b>Дүн</b>				
Автобус тээврийн үйлчилгээ (ННТГ)				
12	Нийтийн тээврийн үйлчилгээ	Өдөрт 12 цаг х 14 хоног х 2ш	60,000	<b>20,100,000</b>
<b>Дүн</b>				<b>20,100,000</b>
Хог цэвэрлэгээ, тээвэр (ХТГ)				
13	Хог тээвэр ачилтын зардал	6 удаа	150,000	900,000
<b>Дүн</b>				<b>900,000</b>
<b>Нийт дүн</b>				<b>94,780,740</b>

--- оОо ---